



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/80/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг, Сайншанд сум)
2020 он

Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
Утас: 70522734	Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер:	Э.Энхцэцэг
Утас: 70523020	Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn.
Аудитор:	Г.Энхтөр
Утас: 99032916	Цахим хаяг: ij17.audit@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12.	Шилэн дансны мэдээлэл	9
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Срон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙХАНДУЛААН
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Х.БАТЧИМЭГ ТАНАА

2020.02.28 № 1-6/244
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Х.Батчимэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 17-ноос 2020 оны 2 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар Ингүүмэл жаргалант аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн

аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь багш бүр хичээл, сургалтын бэлтгэлийг чанартай ханган, үр дүнтэй хэрэгжүүлж, багш, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, суралцагчийн хөгжил, төлөвшилд ахиц гаргах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Байгууллагын үүсгэн байгуулах баримт бичигт зааснаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа.

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд

төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 34 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж байгаа тул нийт зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой юм.

2019 оны нийт зардал 84,742.23 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 847.42 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,366.70 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	137.50	137.50	-
Урьдчилгаа			-
Бараа материал	26,097.00	26,161.90	64.90
Үндсэн хөрөнгө	105,450.60	103,019.00	(2,431.60)
Нийт хөрөнгө	131,685.10	129,318.40	(2,366.70)
Өр төлбөр	584.80	445.40	(139.40)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	131,100.30	128,873.00	(2,227.30)

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	131,685.10	129,318.40	(2,366.70)
---	-------------------	-------------------	-------------------

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн өөрчлөлт нь тухай санхүүгийн жилд аймгийн Засаг даргын санхүүгийн дэмжлэг болох 7,904.0 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтаар 7,850.0 мянган төгрөгөөр, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 54.0 мянган төгрөгөөр тус тус үндсэн хөрөнгө нэмэгдсэн, ашиглах жилийн дагуу 47,478.7 төгрөгийн элэгдэл тооцож үндсэн хөрөнгийн дансны үнэ буурснаас шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 155,615.20 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нийт зардлын 139,802.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 15,912.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 155,135.88 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

Нэмэлт төсөв: Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого болон нэмэлт санхүүжилт байхгүй.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар мөнгөн дүнгээр илэрхийлэгдээгүй 4 асуудлыг алдаа зөрчилд тооцон алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан бусад чухал асуудал байхгүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэг нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээлэл байршуулахаас 149 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнөөс зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу хөтөлдөггүй байна.
2. Цалин олгохдоо ажилтан тус бүрийн арилжааны банк дахь хувийн дансанд шилжүүлэхээр цалин олгох жагсаалт /НХМаягт ЦХ-5б/ үйлдэн нийт дүнгээр холбогдох банкны дансанд шилжүүлдэг ба жагсаалтыг банкны ажилтан хүлээн авсан тухай баримтжуулаагүй байна.
3. Нярвын бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнгээр бус нийт дүнгээр тайлагнасан байна.
4. Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан үндсэн хөрөнгөтэй холбоотой анхан шатны маягтуудыг үндэслээгүй, бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-н маягтаар тайлагнасан байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын газарт 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.1.1 Илрүүлэлт:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу хөтөлдөггүй байна. Энэ нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх, ээлжийн амралтын тооцоог зөрүүтэй тооцох.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу цэцэрлэгийн эрхлэгч хариуцан үнэн зөв хөтлөх бөгөөд нягтлан бодогч уг мэдэгдлийг үндэслэн ээлжийн амралтын тооцоо, олговрыг бодож холбогдох санхүүгийн баримтын хамт хадгална.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

3.2 Дотоод аудит

3.2.1 Илрүүлэлт:

Цалин олгохдоо ажилтан тус бүрийн арилжааны банк дахь хувийн дансанд шилжүүлэхээр цалин олгох жагсаалт /НХМаягт ЦХ-56/ үйлдэн нийт дүнгээр холбогдох банкны дансанд шилжүүлдэг ба жагсаалтыг банкны ажилтан хүлээн авсан тухай баримтжуулаагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Цалин олгох жагсаалт /хүснэгт НХМаягт ЦХ 56/-ыг банкны ажилтан хүлээн авсан тухай баталгаажуулалтыг холбогдох банкнаас авах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

3.3 Балансын данстай холбоотой асуудал.

3.3.1 Илрүүлэлт:

Нярвын бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнгээр бус нийт дүнгээр тайлагнасан байна

Энэ нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Бараа материалын нэр төрөл өөрчлөгдөх, тодорхой бус болох эрсдэлтэй.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн А/40 тоот тушаалыг эрхлэгч, нягтлан бодогч, эд хариуцагч нар сайн судалж хэрэгжүүлж ажиллах. Дээрх заавар, НБББББ-т зааснаар бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Нягтлан бодогч нь бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нарын хөтөлж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

3.4.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан үндсэн хөрөнгөтэй холбоотой анхан шатны маягтуудыг үндэслээгүй, бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-н маягтаар тайлагнасан байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг анхан шатны баримтгүйгээр тайлагнах.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодогч Сангийн сайдын 2018 оны 100 тоот тушаалаар баталсан үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл /ҮХ-1/-г хөтлөхдөө Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан анхан шатны баримт болох ҮХ-1, ҮХ-2, ҮХ-3, ҮХ-4 маягтуудыг үндэслэх бөгөөд дээрх бүртгэл, маягтуудыг холбогдох санхүүгийн баримтын хамт

хадгална. Иймд Сангийн сайдын баталсан дээрх заавар маягтуудыг судлан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй.

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,234,489.59	26,299,389.59
27	АВЛАГА	137,484.00	137,484.00
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	97,882.00	97,882.00
34	Бусад авлага	39,602.00	39,602.00
36	Хувь хүмүүсээс авах авлага	39,602.00	39,602.00
60	БАРАА МАТЕРИАЛ	26,097,005.59	26,161,905.59
61	Түүхий эд материал	17,500.00	-
63	Эм боох материал	17,500.00	-
66	Хангамжийн материал	26,079,505.59	26,161,905.59
67	Бичиг хэргийн материал	256,400.00	386,400.00
68	Аж ахуйн материал	23,491,155.59	24,966,855.59
72	Хүнсний материал	2,331,950.00	808,650.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	105,450,602.63	103,018,997.43
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	105,450,602.63	103,018,997.43
108	Биет хөрөнгө	102,594,602.63	100,162,997.43
109	Барилга, байгууламж	82,514,380.00	82,514,380.00
110	Хуримтлагдсан элэгдэл	-	(4,689,733.32)
113	Машин, тоног төхөөрөмж	25,005,295.00	31,725,295.00
114	Хуримтлагдсан элэгдэл	(16,375,906.20)	(18,050,647.00)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,978,265.24	19,108,265.24
116	Хуримтлагдсан элэгдэл	(12,071,082.82)	(13,212,213.82)
122	Бусад үндсэн хөрөнгө	14,150,000.00	14,150,000.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(8,696,148.59)	(11,526,148.67)
125	Номын фонд	89,800.00	143,800.00
126	Биет бус хөрөнгө	2,856,000.00	2,856,000.00
129	Бусад биет бус хөрөнгө	2,856,000.00	2,856,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	131,685,092.22	129,318,387.02
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	584,825.00	445,399.00
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	584,825.00	445,399.00
164	Өглөг	584,825.00	445,399.00
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	539,167.00	439,741.00
170	Бусад өглөг	45,658.00	5,658.00
171	Байгууллагад төлөх өглөг	42,000.00	2,000.00
172	Хувь хүмүүст төлөх өглөг	3,658.00	3,658.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	131,100,267.22	128,872,988.02
215	Засгийн газрын хувь оролцоо	131,100,267.22	128,872,988.02
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	306,161,149.92	306,161,149.92
217	Өмч: -Төрийн өмч	306,161,149.92	306,161,149.92
223	Хуримтлагдсан үр дүн	(178,466,622.63)	(180,693,901.83)
224	Өмнөх үеийн үр дүн	(178,466,622.63)	(178,466,622.63)
225	Тайлант үеийн үр дүн	-	(2,227,279.20)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,405,739.93	3,405,739.93
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	131,685,092.22	129,318,387.02

4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	128,771,100.00	155,769,200.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	910,000.00	54,000.00
77	Нийтлэг татварын бус орлого	910,000.00	54,000.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	910,000.00	54,000.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	910,000.00	54,000.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	15,912,300.00
119	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	127,861,100.00	139,802,900.00
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	15,912,300.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	15,912,300.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	132,779,991.22	157,996,479.20
148	УРСГАЛ ЗАРДАЛ	132,779,991.22	157,996,479.20
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	131,944,370.22	157,417,161.20
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	80,278,776.00	101,442,362.00
151	Цалин	80,278,776.00	101,442,362.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,738,086.00	11,291,200.00
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	6,534,641.00	8,430,500.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	788,418.00	629,500.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	682,136.00	697,300.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	170,509.00	139,400.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,562,382.00	1,394,500.00
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,662,290.00	15,101,394.00
165	Гэрэл цахилгааны зардал	14,512,290.00	14,196,394.00
167	Цэвэр, бохир усны зардал	1,150,000.00	905,000.00
170	Хангамж, бараа материалын зардал	2,297,270.00	5,026,480.00
171	Бичиг хэргийн материал	212,210.00	22,000.00
172	Тээвэр, шатахууны зардал	530,000.00	976,950.00
173	Шуудан холбоо интернэтийн төлбөр	262,300.00	260,000.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	346,800.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,292,760.00	3,420,730.00
181	Нормативт зардал	13,064,120.00	12,147,410.00
182	Эм	3,000.00	35,000.00
183	Хоол	13,011,120.00	12,112,410.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50,000.00	-
185	Эд хогшил, урсгал засварын зардал	156,000.00	200,000.00
189	Урсгал засвар	156,000.00	200,000.00
190	Томилолт, зочны зардал	206,000.00	372,000.00
192	Дотоод томилолтын зардал	206,000.00	372,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	750,260.00	891,000.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	750,260.00	691,000.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	200,000.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	9,791,568.22	10,945,315.20
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	724,000.00	609,710.00

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,067,568.22	10,335,605.20
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	835,621.00	579,318.00
228	Бусад урсгал шилжүүлэг	-	100,000.00
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	100,000.00
237	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	835,621.00	52,812.00
240	Төвлөрүүлэх шилжүүлэг	835,621.00	52,812.00
242	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	426,506.00
245	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	426,506.00
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(4,008,891.22)	(2,227,279.20)
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	162,306,359.96	-
283	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	162,306,359.96	-
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(162,306,359.96)	-
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(166,315,251.18)	(2,227,279.20)

4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	127,861,100.00	155,715,200.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	127,861,100.00	155,715,200.00
118	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	127,861,100.00	139,802,900.00
129	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	15,912,300.00
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	15,912,300.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	124,988,200.00	147,865,200.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	124,988,200.00	147,865,200.00
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	124,152,579.00	147,285,882.00
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	80,461,400.00	101,575,879.00
151	Үндсэн цалин	76,870,300.00	81,584,062.00
152	Нэмэгдэл	3,591,100.00	5,845,200.00
154	Үр дүнгийн урамшуулал	-	14,146,617.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,071,461.00	11,291,100.00
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	6,149,670.00	6,761,000.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	529,600.00	906,000.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	845,100.00	1,132,500.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	162,700.00	226,500.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,384,391.00	2,265,100.00
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	15,652,290.00	15,285,794.00
165	Гэрэл цахилгааны зардал	14,512,290.00	14,370,794.00
167	Цэвэр, бохир усны зардал	1,140,000.00	915,000.00
170	Хангамж, бараа материалын зардал	4,265,060.00	3,810,090.00
171	Бичиг хэрэг	60,000.00	60,000.00
172	Тээвэр, шатахуун	530,000.00	920,000.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	270,100.00	270,090.00
174	Ном, хэвлэл	130,000.00	130,000.00
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	687,000.00

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,274,960.00	1,743,000.00
181	Нормативт зардал	11,838,198.00	10,906,619.00
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,500.00	17,500.00
183	Хоол, хүнс	11,520,798.00	10,589,119.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	299,900.00	300,000.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	140,000.00	1,850,000.00
186	Багаж техник хэрэгсэл	-	120,000.00
187	Тавилга	-	1,530,000.00
189	Урсгал засвар	140,000.00	200,000.00
190	Томилолт, зочны зардал	206,000.00	372,000.00
192	Дотоод албан томилолт	206,000.00	372,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	843,000.00	893,400.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	843,000.00	693,400.00
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	200,000.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	1,675,170.00	1,301,000.00
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,675,170.00	1,301,000.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	835,621.00	579,318.00
225	Бусад урсгал шилжүүлэг	-	100,000.00
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	100,000.00
234	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	835,621.00	52,812.00
237	Төвлөрүүлэх шилжүүлэг	835,621.00	52,812.00
239	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	426,506.00
242	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	426,506.00
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,872,900.00	7,850,000.00
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,872,900.00	7,850,000.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,872,900.00	7,850,000.00
263	Дотоод эх үүсвэрээр	2,872,900.00	7,850,000.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,872,900.00	7,850,000.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,872,900.00)	(7,850,000.00)
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	303,305,149.92	3,405,739.93	(12,212,301.45)	294,498,588.40
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			60,930.00	60,930.00
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	303,305,149.92	3,405,739.93	(12,151,371.45)	294,559,518.40
5	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				-
6	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				-
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	2,856,000.00		(166,315,251.18)	(163,459,251.18)
9	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	306,161,149.92	3,405,739.93	(178,466,622.63)	131,100,267.22
10	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	306,161,149.92	3,405,739.93	(178,466,622.63)	131,100,267.22
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	306,161,149.92	3,405,739.93	(178,466,622.63)	131,100,267.22
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(2,227,279.20)	(2,227,279.20)
18	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	306,161,149.92	3,405,739.93	(180,693,901.83)	128,872,988.02

4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2 I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	155,715,200.00	155,235,882.00	479,318.00	99.69
3 УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	155,715,200.00	155,235,882.00	479,318.00	99.69
4 Бараа, үйлчилгээний зардал	155,615,200.00	155,135,882.00	479,318.00	99.69
5 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	102,828,000.00	101,575,879.00	1,252,121.00	98.78
6 Үндсэн цалин	82,828,600.00	81,584,062.00	1,244,538.00	98.50
7 Нэмэгдэл	5,845,200.00	5,845,200.00	-	100.00
9 Урамшуулал	14,154,200.00	14,146,617.00	7,583.00	99.95
11 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,080,400.00	11,291,100.00	(1,210,700.00)	112.01
12 Тэтгэврийн даатгал	5,550,300.00	6,761,000.00	(1,210,700.00)	121.81
13 Тэтгэмжийн даатгал	906,000.00	906,000.00	-	100.00
14 ҮОМШӨ ний даатгал	1,132,500.00	1,132,500.00	-	100.00
15 Ажилгүйдлийн даатгал	226,500.00	226,500.00	-	100.00
16 Эрүүл мэндийн даатгал	2,265,100.00	2,265,100.00	-	100.00
17 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,712,300.00	15,285,794.00	426,506.00	97.29
18 Гэрэл цахилгаан	14,512,300.00	14,370,794.00	141,506.00	99.02
20 Цэвэр, бохир ус	1,200,000.00	915,000.00	285,000.00	76.25
22 Хангамж, бараа материалын зардал	3,810,100.00	3,810,090.00	10.00	100.00
23 Бичиг хэрэг	60,000.00	60,000.00	-	100.00
24 Тээвэр (шатахуун)	920,000.00	920,000.00	-	100.00
25 Шуудан холбоо, интернэтийн төлбөр	270,100.00	270,090.00	10.00	100.00
26 Ном, хэвлэл	130,000.00	130,000.00	-	100.00
27 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	687,000.00	687,000.00	-	100.00
28 Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,743,000.00	1,743,000.00	-	100.00
30 Нормативт зардал	10,906,700.00	10,906,619.00	81.00	100.00
31 Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,500.00	17,500.00	-	100.00
32 Хоол, хүнс	10,589,200.00	10,589,119.00	81.00	100.00
33 Нормын хувцас зөөлөн эдлэл	300,000.00	300,000.00	-	100.00
34 Эд хогшил худалдан авах	9,700,000.00	9,700,000.00	-	100.00
35 Багаж, техник, хэрэгсэл	6,365,000.00	6,365,000.00	-	100.00
36 Тавилга	3,135,000.00	3,135,000.00	-	100.00
38 Урсгал засвар	200,000.00	200,000.00	-	100.00
39 Томилолт, зочны зардал	383,300.00	372,000.00	11,300.00	97.05
41 Дотоод албан томилолт	383,300.00	372,000.00	11,300.00	97.05
43 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	893,400.00	893,400.00	-	100.00
44 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	693,400.00	693,400.00	-	100.00
45 Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	200,000.00	200,000.00	-	100.00

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

53	Бараа үйлчилгээний бусад зардал	1,301,000.00	1,301,000.00	-	100.00
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,301,000.00	1,301,000.00	-	100.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,000.00	100,000.00	-	100.00
70	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	100,000.00	-	100.00
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	100,000.00	100,000.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	155,715,200.00	155,715,200.00	-	100.00
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	139,802,900.00	139,802,900.00	-	100.00
101	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	139,802,900.00	139,802,900.00	-	100.00
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,912,300.00	15,912,300.00	-	100.00
104	Орон нутгийн төсвөөс	15,912,300.00	15,912,300.00	-	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	-	-	-
134	Удирдах ажилтан	-	-	-	-
135	Гүйцэтгэх ажилтан	-	-	-	-
136	Үйлчлэх ажилтан	-	-	-	-
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-